

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн
354 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Хотын стандарт, хяналтын газар

Албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга

Нэгжийн нэр:

Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1200, Нийслэлийн Нутгийн Захиргааны цогцолбор байр.

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилт:

Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Барилгын тухай, Орон сууцны тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Хот байгуулалтын тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, стандарт норм дүрмийн мөрдөлтөд хяналт тавих, илэрсэн зэрчил дутагдлыг арилгуулах, улсын байцаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Барилгын салбар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, стандарт нормын мөрдөлтийг нийслэлийн хэмжээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж, хяналт тавих.
- Барилгын салбарын холбогдох хууль, тогтоомж болон Засгийн газар, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, хэлтсийн улсын (ахлах) байцаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, чиглүүлэх, үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг үнэлэх.
- Төрийн албаны хууль тогтоомжоор хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, хэлтсийн албан хаагчдыг өдөр тутмын үйл ажиллагаагаар хангах, зохион байгуулах.
- Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж гүйцэтгэлд хяналт тавих, тайлagnaх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Хяналтын улсын (ахлах) байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	1.2.Холбогдох байгуулагатай хамтран зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд томилох санал гаргах, татан оролцуулах;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г, Х
	1.3.Холбогдох асуудлаар ажлын хэсэг, комисс, тендерийн болон техникийн хороо зэрэгт ажиллах, шаардлагатай албан хаагчдыг томилж оролцуулах;	Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна.	Г, Х, Ш
	1.4.Байгууллагын үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээллэх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах;	Олон нийтэд мэдээлсэн байна.	Г, Х
	1.5.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг удирдах, нэгдсэн зохион байгуулалтаар хангах;	Зөрчлийг бүрэн арилгуулсан байна.	Г
	1.6.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт	Дүүрэг, холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдэд зөвлөн тусалж, сургалт арга	Т, Г, Х



	зохион байгуулах;	зүйгээр хангагдсан байна.	
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Засгийн газар, Салбарын хяналтын газар, НИТХ, Нийслэлийн Засаг даргын бодлого, төлөвлөлтийн холбогдох заалтыг Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэгжилтийн талаар судлах, үр дүнг газрын даргад танилцуулах;	Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна.	Г, Х
	2.2.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулах, гүйцэтгэлийг тайлагнах;	Зорилт, арга хэмжээний биелэлт зорилтот түвшинд хурсэн байна.	Г, Х, Ш
	2.3.Хариуцсан хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгур үзүүлэлт, хяналтын хуудсыг боловсронгуй болгох саналыг нэгтгэн салбарын хяналтын газарт хүргүүлэх, хяналт шалгалтын объектын эрсдэлийг үнэлгээ, гүйцэтгэсэн байдлыг нэгтгэн салбарын хяналтын ерөнхий байцаагч болон газрын удирдлагад танилцуулах;	Эрсдэлд сууринсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Г, Х
	2.4.Цаг үеийн шинжтэй болон онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу хариуцсан хяналтын улсын (ахлах) байцаагчдыг удирдлага зохион байгуулалтаар хангах;	Оновчтой арга зүйг ашиглан үнэн, бодит үр дүнг тодорхойлж тухайн асуудлыг үр ашигтай шийдвэрлэх санал дэвшүүлсэн байна.	Г, Х, Ш
	2.5.Хариуцсан чиглэлээр хяналтын улсын (ахлах) байцаагчийн эрх зүйн баримт бичиг, албан бичгийг хянах, зохих стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх, сургаж мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;	Зорилт, арга хэмжээний биелэлт зорилтот түвшинд хурсэн байна.	Г, Х, Ш
	3.1.Бодлогын баримт бичигт тусгагдсан тухайн хяналтын чиглэлд хамааралтай зорилт, арга хэмжээний биелэлтийг	Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна.	Г, Х



	хяналтын улсын (ахлах) байцаагч нараас гаргуулан авч нэгтгэн танилцуулах;		
3 дугаар зорилтын хурээнд	3.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хяналтын улсын (ахлах) байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой болон бусад өргөдөл, гомдлыг хянан үзэж, газрын даргад танилцуулах, холбогдох арга хэмжээг авах талаар санал өгөх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	3.3.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад газрын даргад дэмжлэг үзүүлэх, хяналтын улсын (ахлах) байцаагчдад үүрэг чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;	Үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах.	Г, Х, Ш
	3.4.Тушаал шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах;	Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, тухай бүр танилцуулсан байна.	Г
	3.5.Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хууль журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хурээнд	4.1.Газрын удирдлагаас өгч буй үүрэг, цаг үеийн арга хэмжээнд оролцох, эргэн тайлагнах;	Үүрэг даалгаврын дагуу ажил, үүргийг хийж гүйцэтгэсэн байна.	Г
	4.2.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах, хянах;	Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, ажил үйлчилгээ үр дүнтэй хэрэгжиж, үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	4.3.Нэгжийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах;	Удирдлагаар ханган ажилласан байна.	Г, Х
	4.4.Нэгжийн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, тайлан, судалгаа гаргах, танилцуулах ажлыг хянах;	Мэдээ, тайлан, судалгаа үнэн зөв, хугацаандаа гарсан байна.	Х
	4.5.Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ХАСХОМ-ийг хуулийн	Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөж, авлига,	Г



	хугацаанд зохих журмын дагуу тухай бүр мэдүүлж байх;	сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан ажилласан байна.	
	4.6.Баримт бичиг зохион бурдүүлэх, ёсчлоходоо MNS 5140:2011, MNS 5141:2011, MNS 5142:2011 цуврал стандартад тодорхойлсон техникийн шаардлагуудыг мөрдлөг болгон ажиллаж, зохион бурдүүлсэн баримтаараа ХХНЖ-ын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн дараа оны эхний улиралд багтаан байгууллагын архивд хүлээлгэн өгөх;	Стандартад тодорхойлсон техникийн шаардлагуудыг мөрдлөг болгон ажилласан байна.	Г
	4.7.Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур чадвараа тогтмол дээшлүүлэх;	Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур чадвараа тогтмол дээшлүүлэн ажилласан байна.	Г
	4.8.Газрын хөдөлмөрийн дотоод журам, газрын үйл ажиллагааны хүрээнд гарсан бусад дүрэм журам, зааврыг мөрдөж ажиллах.	Дүрэм журам, зааврыг мөрдөж ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Архитектур, хот төлөвлөлт /0731/ (073104, 073107); - иргэний ба үйлдвэрийн барилга байгууламж /0732/; - материал судлал инженерчлэл /072201/. 		
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх; - мэргэшсэн инженер, архитектор байх, 		
Туршлага	<ul style="list-style-type: none"> - Төрийн албанад 6-аас доошгүй жил, үүнээс дээш түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх. - Улсын байцаагчаар 3-аас дээш жил ажилласан байх. 		
Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх. - үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, арга хэмжээ төлөвлөх. - албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй хуваарилах. - цаг үеийн шуурхай үүрэг даалгаврыг албан хаагчдад оновчтой хуваарилах. - бусад. 		



	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, харьцуулалт, шинжилгээ хийх, нэгтгэж дүгнэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж, боловсруулах; - шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - бусад.
Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлох; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагавар, эрсдэлийг хариуцах; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалzan үздэг байх; - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ёс зүй, хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтаар хамт олныг үлгэрлэн манлайлах; - шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - итгэлцлийг бий болгох, албан хаагчдад адил тэгш хандах, зөв шударгаар дүгнэх; - шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих, үр дүнтэй өөрчлөлт, шинэтгэлийг дэмжин хэрэгжүүлдэг байх; - зарчимч, ажил хэрэгч чанараар хамт олныг үлгэрлэх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх. - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох. - төрийн албан хэрэг хөтлөлт, монгол хэлний зөв бичих, найруулга зүйн чадвартай байх. - байгууллага, хувь хүний нууцыг хадгалах. - кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Хотын стандарт, хяналтын газрын дарга.

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u>
<ul style="list-style-type: none"> - Ахлах мэргэжилтэн 2; - Барилгын техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч 16; - Мэргэжилтэн 3; Нийт-21. 	<ul style="list-style-type: none"> - Барилга хот, байгуулалтын яам; - Салбарын хяналтын газар; - Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газар; - Барилгын хөгжлийн төв ТӨҮГЛС; - Ус сувгийн удирдах газар; - Нутгийн захиргааны байгууллага болон холбогдох албан тушаалтан; - Төрийн болон төрийн буюу байгууллага;



- Иргэн, хуулийн этгээд;

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

..... Э.ДАВААХАТАН
20~~22~~ оны ~~08~~ дугаар сарын ~~01~~ -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо 23.08.14

Дугаар 354

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023.08.21

Дугаар: A/43

(тамга/тэмдэг)

ДАРГА

2023 оны 08 дугаар сарын 01 -ны өдөр

8314551- СБТ1762

С.ТӨМӨРДУДАМ

